

**УЛААНБААТАР ХОТ БАЯНЗҮРХ ДҮҮРГИЙН НУТАГТ ОРШИХ “ЭВТ ЧУЛУУ”  
ХХК-ИЙН БАРИЛГЫН МАТЕРИАЛЫН ОРДЫН-Н 2025 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ  
МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТИЙН ТАЙЛАН**

ТҮГЭЭМЭЛ ТАРХАЦТАЙ АШИГТ МАЛТМАЛ АШИГЛАЛТЫН ТУСГАЙ  
ЗӨВШӨӨРЛИЙН ДУГААР: MV-21/M043  
АЖ АХУЙН НЭГЖИЙН РЕГИСТРИЙН ДУГААР: 5053986

**Хянасан:**

БОАЖЯ-ны ХБОБНУГ-ын мэргэжилтэн

/...../

**Биелэлтийг тайлагнасан:**

“Эвт чулуу” ХХК-ний

/

/

Байгаль орчны инженер

/Ц.Батсайхан/

## АГУУЛГА

1. ТӨСЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА .....	3
2. ТӨСӨЛ ХЭРЭГЖҮҮЛЖ БУЙ ГАЗРЫН ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ.....	3
3. УУРХАЙН ГОЛ БА БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙН ТОВЧ ТОДОРХОЙЛОЛТ.....	8
4. ЦАГААН ДАВААНЫ ЧУЛУУН ОРДЫН УУРХАЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ, ҮНДСЭН ҮР ДҮН.....	12
5. СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ .....	14
6. НӨХӨН СЭРГЭЭХ АЖЛЫН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ .....	19
7. БИОЛОГИЙН ОЛОН ЯНЗ БАЙДЛЫГ ДҮЙЦҮҮЛЭН ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ .....	21
8. НҮҮЛГЭН ШИЛЖҮҮЛЭХ, НӨХӨН ОЛГОВОР ОЛГОХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ .....	21
9. ТҮҮХ, СОЁЛЫН ӨВИЙГ ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ.....	21
10. ОСОЛ ЭРСДЭЛИЙН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ.....	21
11. ХОГ ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ .....	26
12. ОРЧНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨРИЙН БИЕЛЭЛТ .....	28
14. УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ ...	29
15. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨГ ХЭРЭГЖҮҮЛЭХЭД ГАРСАН НИЙТ ЗАРДЛЫН ХЭМЖЭЭ .....	31
16. ДҮГНЭЛТ .....	32
17. ХАВСРАЛТУУД.....	Error! Bookmark not defined.

## 1. ТӨСЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

“Эвт чулуу” ХХК-ийн Барилгын чулууны орд нь Улаанбаатар хотын Баянзүрх дүүргийн 21,22-р хорооны нутагт орших бөгөөд хотын төвөөс зүүн хойно 9 орчим км зайтай, Монелийн эцсээс 1.5 км, Цагаан давааны урд хэсэгт байрлана. Монелийн эцсийн буудлаас 1 км шороон замаар явж төслийн талбайд хүрнэ. Нийт 47.9 га талбайд хэрэгжинэ.

“Цагаан давааны урд” барилгын чулууны ордын нөөцийн талбайн булангийн цэгүүд нь L-48-10 планшейтын талбайн хэмжээнд дараах газар зүйн солбилцолын хүрээнд хамаарна.

21/М043 тусгай зөвшөөрөлийн талбайн газарзүйн солбилцолууд

1.  $106^{\circ}58'11.00''$   $47^{\circ}57'45.75''$
2.  $106^{\circ}58'38.00''$   $47^{\circ}57'45.75''$
3.  $106^{\circ}58'38.00''$   $47^{\circ}57'25.00''$
4.  $106^{\circ}58'20.00''$   $47^{\circ}57'25.00''$
5.  $106^{\circ}58'20.00''$   $47^{\circ}57'35.00''$
6.  $106^{\circ}58'11.00''$   $47^{\circ}57'35.00''$

Зураг 1. Төслийн байршилний зураг



**Зам тээврийн нөхцөл:** “Эвт чулуу” ХХК-ийн Барилгын чулууны орд нь Улаанбаатар хотын Баянзүрх дүүргийн 21,22-р хорооны нутагт орших бөгөөд хотын төвөөс зүүн хойно 9 орчим км зайтай, Монелийн эцсээс 1.5 км, Цагаан давааны урд хэсэгт байрлана. Монелийн эцсийн буудлаас 1 км шороон замаар явж төслийн талбайд хүрнэ. Нийт 47.9 га талбайд хэрэгжинэ. 1.2.2. Уур амьсгал

“Эвт чулуу” ХХК-ийн Цагаандавааны барилгын чулууны орд нь Улаанбаатар хотын Баянзүрх дүүргийн нутагт орших бөгөөд төсөл хэрэгжих бүс нутгийн уур амьсгалыг бүрдүүлэгч олон хүчин зүйлсийн харилцан үйлчлэлийн нөлөөгөөр тухайн газар орны уур амьсгалын нөхцөл бүрэлдэн тогтоно. Нарны цацрагийн жилийн явцаас хамааран сэрүүн бүсэд жилийн дөрвөн улирал ээлжилдэг. Тухайн орон нутгийн хотгор гүдгэр, газрын гадаргын шинж зэргээс хамааран улирлын шинж газар бүр харилцан адилгүй байдаг. Төсөл хэрэгжих орчмын бүс нутаг нь уур амьсгалын эх газрын эрс тэс шинжтэй. Энд өвөл нь хүйтэн бөгөөд удаан үргэлжилнэ. Зун нь богино, халуун болдог. Хавар, намрын улиралд цаг агаар тогтворгүй эрс өөрчлөгдөж байдаг.

Өвөл: Улаанбаатар хотод өвлийн улирал 10 дугаар сарын 27-оос дараа оны 3 дугаар сарын 29 хүртэл 153 хоног үргэлжилж байна. Энэ нь манай орны нутгийн дундаж хугацаанаас арай урт байна. Өвлийн улирлын гол нь онцлог нь цаг агаар тогтуун болж, нарны өндөр хамгийн бага болж нарны тусгалын илч багасан, цасан бүрхүүл зузааран, хунгарлана. Хүйтний эрч туйлдаа хүрч зарим үед  $-47^{\circ}\text{C}$  болох тохиолдол цөөнгүй.

Хавар: Хаврын улирал өвлийн төгсгөлөөс дунджаар 5 дугаар сарын 17 хүртэл 49 хоног үргэлжилдэг. Хаврын гол онцлог нь өвлийн цаг агаарын эсрэг циклонлог тогтоц задарч цаг агаарын шинж хувирамтгай болж хоног хоногоор дулаардагч хоногийн температурын агууриг бусад улирлынхаас ихсэж, хахиршил нэмэгдэж ялангуяа хаврын эхэн хэсэгт хүйтэн жавартай байдаг.

Зун: Зуны улирал дулааны шинжээрээ харьцангуй урт үргэлжилдэг. Манай орны бүс нутгуудын нэгэн адил зун 5 дугаар сарын 17-ноос эхлэн 9 дүгээр сарын 7 хүртэл 113 хоног үргэлжилнэ. Зуны улиралд агаар мандлын бага даралтын орон бүрэлдэх, хур тунадасны 75 орчим хувь нь унаж, ус чийг ихсэж зарим тохиолдолд аадар борооны нөлөөгөөр үер усны их буулт болж, замын далан болон гүүр гарцны зарим хэсэгт нөлөөлж болзошгүйг анхаарах шаардлагатай. Мөн дулааны хэмжээ туйлдаа хүрч хамгийн халуун нь  $+38^{\circ}\text{C}$  хөрсний гадаргад

+65°C хүрнэ. Заримдаа бүгчим халуун, аадар, аянга, ус, үер зэрэг байгалийн гамшигт үзэгдэл гарах магадлалтай байдаг.

Намар: Намрын улирад зуны төгсгөлөөс өвлийн эхэн хүртэл (7.IX-27.X) 50 хоног үргэлжилж өвлийн эхэн үед аажимдаа шилжинэ. Намрын уур амьсгалын байгаль орчны гол шинж нь хоног хоногоор сэрүүсч шүүдэр, хяруу унаж, цас мөсний үзэгдэл намрын эцсээр үүсч, хур татарч, газар шороо өнгөнөөсөө хөлдөж, өдөр богиносдог.

### 1.2.3. Агаарын чанарын төлөв байдал

Төслийн талбай, түүний орчмын агаарын чанарт үзүүлж буй нөлөөллийг тогтоох зорилгоор эдэлбэр газрын хил дотор 3 цэгт хэмжилт хийж, үр дүнг боловсруулав.

Баримтлах хууль, стандарт шаардлага:

- Агаарын тухай хууль
- MNS 4585:2016. Агаарын чанар. Техникийн ерөнхий шаардлага
- MNS 5885:2008. Агаарт байх бохирдуулах бодисын хүлцэх хэм хэмжээ.

Техникийн ерөнхий шаардлага

Төслийн хувьд агаар бохирдуулах гол эх үүсвэр нь тээврийн хэрэгслийн утаа, тээврийн хэрэгслийн хөдөлгөөнөөр агаарт бохирдуулагч бодис ялгарах, тоосжих зэрэг юм. Агаарын чанарт үзүүлж буй нөлөөллийг тогтоох зорилгоор эдэлбэр газрын хил дотор 3 цэгт хэмжилт хийж, үр дүнг боловсруулахдаа Монгол улсад мөрдөгдөж байгаа стандартад, аргачлал болон багажит шинжилгээний аргыг ашиглан агаар бохирдуулагчийг тодорхойлсон.

### 1.2.4. Усан орчны төлөв байдал

Гадаргын ус: “Эвт чулуу” ХХК-ийн Урд Цагаандавааны барилгын чулууны орд нь Улаанбаатар хотын Баянзүрх дүүргийн 21, 22-р хороодын нутаг дэвсгэрт орших бөгөөд усзүйн хувьд Хойд мөсөн далайн голуудын ай сав Туул голын сав газарт хамаарагдана. Төслийн талбай, түүний орчимд нуур, булаг шанд, гол мөрөн, гүний худаг байхгүй. Төслийн талбайтай хамгийн ойр орших гадаргын урсац нь төслийн талбайгаас зүүн тийш 3.3 км зайд урсах Улиастай гол юм. Төслийн талбай нь “Улаанбаатар хотын ус хангамжийн эх үүсвэрийн эрүүл ахуйн бүс, тэжээгдлийн мужийн заагийг тогтоох тухай” Байгаль Орчин Аялал Жуулчлалын Сайд, Барилга, хот байгуулалтын сайдын 2018 оны 01 сарын 03-ны өдрийн А/02/01 дугаар бүхий хамтарсан тушаалаар тогтоосон Улаанбаатар хотын ус хангамжийн эх үүсвэрийн эрүүл ахуйн хориглолтын бүсийн хилийн зааг, хязгаарлалтын бүсийн хилийн зааг болон ус хангамжийн эх үүсвэрийн тэжээгдлийн мужийн хилийн заагтай давхцалгүй байна.

#### 1.2.5. Хөрсөн орчны төлөв байдал

Судалгаанд хамрагдсан Улаанбаатар хотын Баянзүрх дүүргийн 21,22-р хорооны нутагт байрлах “Цагаан давааны урд нэртэй барилгын чулууны орд ашиглах” төслийн талбай нь хөрсний газарзүйн мужлалтаар (Доржготов Д., УБ 1984, 1994) хөрс-био уур амьсгалын Хангайн их мужийн Хэнтийн өмнөх тойрогт багтах бөгөөд Туул голын өргөн хөндий, Хэнтийн нурууны салбар уулын энгэр хажуугаар ихэвчлэн хар хүрэн хөрс зонхилно /Монгол Улсын үндэсний атлас, 2009/. Хөрс судлалын лабораторийн задлан шинжилгээний дүнгээр дээрх 6 төрлийн элементүүд “Хөрсний чанар. Хөрс бохирдуулагч бодис, элементүүдийн зөвшөөрөгдөх дээд хэмжээ MNS 5850:2019” стандартад заасан зөвшөөрөгдөх дээд хэмжээнээс бага буюу бохирдол үүсээгүй байгааг илтгэнэ.

#### 1.2.6. Ургамлан нөмрөгийн хэв шинж

Улаанбаатар хотын Баянзүрх дүүргийн 21,22-р хорооны нутаг дэвсгэрт байрлах “Эвт чулуу” ХХК-ийн “Цагаан давааны урд нэртэй барилгын чулууны орд ашиглах” төслийн талбай нь ургамал газарзүйн мужлалаар Евразийн шилмүүст ойн мужийн Өвөр Байгалийн уулын тайгын хошууны Төв Хэнтийн уулын тайгын тойрог, Евразийн хээрийн мужийн Дагуур-Монголын хээрийн хошууны Өрнөд Хэнтийн уулын хээрийн тойрог, Өмнөд Хэнтийн уулын хээрийн тойрог, Улзын уулын хээрийн тойрогт хамаарагдана. Уг нэгж талбар нь жижиг дэгнүүлт үетэн- алаг өвст бүлгэмдэлтэй. Ургамлан нөмрөгийн тусгаг бүрхэц 60-80%, ойролцоогоор 1.2-1.4 цн/га ургацтай. Ургамлын дундаж өндөр 15-30см. Үетэн 20%-иар зонхилж ургана.

#### 1.2.7. Түүх соёлын өв болон тусгай хамгаалалттай газар нутаг

“Эвт чулуу” ХХК-ийн “Цагаан давааны урд нэртэй барилгын чулууны орд ашиглах” төсөл нь хэрэгжих талбайд одоогоор түүх соёлын дурсгалт зүйл, археологи, палентологийн ховор олдворын зүйл илрээгүй бөгөөд төсийн талбай нь Улсын тусгай хамгаалалттай газар нутгийн аль нэг ангилалд хамаарахгүй.

Төсөл хэрэгжих талбайд түүх соёлын дурсгалт зүйл, археологи, палентологийн ховор олдворын зүйл байхгүй бөгөөд тусгай хамгаалалттай газар нутагт явагдахгүй учир төслөөс ямар нэгэн нөлөөлөлгүй болно. Хэрвээ түүх, соёл, археологийн олдвор илэрвэл холбогдох засаг захиргааны байгууллагад мэдэгдэх хэрэг

**Уурхайн жилийн хүчин чадал:** Техник эдийн засгийн үндэслэлийн дагуу ашиглалтыг явуулж 2024 оны уулын ажлын төлөвлөгөөгөөр 25-32 метрийн түвшин хүртэл гүнзгийрч нийт 20

мян.м<sup>3</sup> хөрс хуулж, 100 мян.тн уулын дайрга олборлох зорилттой ажиллаж байна. Уурхайн ажиллах горим: 2025 онд Барилгын материалын чулууны уурхайн ажиллах горим дараах байдлаар үйл ажиллагаагаа явуулж байна.

*Хүснэгт 3: Уурхайн ажиллах горим*

№	Үзүүлэлт	Хэмжих нэгж	Хэмжээ	Тайлбар
1	Жилийн ажлын горим	5-10 сар		
2	Жилийн календарьт хугацаа	хоног	180	
3	Жилд ногдох ажлын бус хоног	хоног	30	Баяр ёслол
4	Цаг агаарын саатал хүндрэл	хоног	5	
5	Жилд ажиллах хоног	хоног	180	
6	Хоногийн ажлын горим	ээлж	1	
7	Ээлжийн хугацаа	цаг	12	

**Ажиллах хүчний мэдээлэл:** Уурхай нь 2025 оны бүтэц орон тоогоор 35 хүний бүрэлдэхүүнтэй батлагдсан. Одоогийн байдлаар нэг ээлжинд 30-35 хүний бүрэлдэхүүнтэй үйл ажиллагааг явуулж байна.

**Уурхайн дайрга олборлолт болон тээвэрлэлт:** 2025 оны 10-р сарын 01-ны өдрийн байдлаар Дайрганы уурхай өөрийн үйлдвэрүүд болон уурхайн ам нөхцөлөөр нийт 80 мян.тн дайргыг худалдан борлуулсан байна. Дайрга олборлолт, борлуулалтын ажилд Hyundai-850, CAT-395 зэрэг экскаваторууд ажилласан.

**Уурхайд ашиглагдаж буй техник тоног төхөөрөмж:** 2025 онд уурхайн ажилд хэрэглэгдэж буй тоног төхөөрөмжүүдийг хүснэгт 4-т үзүүлэв.

*Хүснэгт 4: Уурхайд ажиллаж буй техникүүдийн жагсаалт*

Техникийн нэр	Марк	Хүчин чадал	Тоо ширхэг	Зориулалт
Экскаватор	CAT-395	6 м <sup>3</sup>	1	Хөрс олборлолт
Автосамосвал	Хово-371	50 тн	2	хөрс, дайрга
Бульдозер	CAT-D9R	18.5 м <sup>3</sup>	1	Шимт хөрс хуулах, овоолго нээж, ул тааз түрэх
Усны белаз	Белаз-76473	32 тн	1	Зам усалгаа хийх
Автогрейдер	CAT-160K		1	Зам талбай тэгшилж янзлах

Дээрх уулын ажлын зориулалттай техникүүдээс гадна түлшний хангамжинд хэрэглэх түлшний тэрэг болон олон төрлийн үйлчилгээний зориулалттай ачигч, галын машин, механик засварын машин зэрэг машин, тоног төхөөрөмжийг уурхайн бусад хэрэглээнд ажиллаж байна.

**Уурхайн барилга байгууламж:** Төслийн талбайд дараах барилга байгууламжууд байна:

- Ажилчдын түр хотхон / амрах байр

- Оффис, сургалтын өрөө
- Зоогийн газар
- Халуун ус, хувцас угаалгын байр
- Засвар үйлчилгээний хэсэг-хаягдал тосыг түр хадгалах цэг
- Сэлбэг хэрэгслийн агуулах
- Хог хаягдлыг ангилан ялгаж түр хадгалах цэг
- 

## **II. УУРХАЙН ГОЛ БА БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙН ТОВЧ ТОДОРХОЙЛОЛТ**

1. “Эвт чулуу” ХХК-ийн “Урд Цагаандавааны барилгын чулууны ордыг ил аргаар ашиглах” төслийн үйл ажиллагаанаас үүсэх сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах арга хэмжээг нөлөөлөлд өртөх газрын гадарга, хэвлий, хөрсөн бүрхэвч, газрын доорх усанд нөлөөлж болзошгүй хэлбэрүүд, түүний шинж чанар зэргийг урьдчилсан байдлаар тодорхойлсон бөгөөд мөн нөлөөллөөс урьдчилан сэргийлэх зорилгоор авах арга хэмжээний чиглэл, зарим зөвлөмж, саналыг товч тусгав. Төслөөс байгаль орчинд үзүүлэх болзошгүй сөрөг нөлөөллүүд:
2. Төслийн олборлолтын үе шатанд буюу хөрс хуулалт, тээвэрлэлт, хадгалалт болон баяжуулах үйл ажиллагааны үед салхины горим, нийлбэр цацрагийн хэмжээ зэрэг хүчин зүйлсийн улмаас үүсэх тоосонцор, шимт хөрснийг хадгалах газрын сонголт, дотоод овоолгоос үүсэх тоосонцорын тархалт зэрэгт нөлөөлөх;
3. Уурхайн карьер, шимт хөрс, хөрсний гадаад, дотоод овоолго болон тээвэрлэлтийн үеийн тоосонцорын тархалт, автомашины утаанаас ялгарах бохирдуулагч бодисууд зэргийн агаар мандал дахь тархалт
4. Уурхайн ашиглалтын үйл ажиллагааны нөлөөгөөр газрын гадаргын үндсэн хэлбэр дүрс их хэмжээгээр өөрчлөгдөж, гүн ухагдсан нүх, ил уурхайн ухааш болон хэт огцом налуутай өндөр овоолгуудаас бий болсон толгод, далан нурууг үүсгэх бөгөөд үүний улмаас тухайн өөрчлөлтөд орсон талбай нь газар ашиглалтын хувьд тохиромжгүй болж хувирах;
5. Ахуйн бохир ус хөрсөнд алдагдах, зөвшөөрөгдөх дээд хэмжээнээс давсан бохирдолтой усыг сумын ус зайлуулах шугамд нийлүүлэх;

6. Орчны тоосжилтод байнгын хяналт тавьж, тоосжилтыг бууруулахын тулд салхи ихтэй, хуурайшилттай үед зам талбайг чийглэж услах;
7. Шимт хөрсний овоолго ургамалжуулан хамгаалах. Энэ нь шимт хөрсний чанарыг алдагдуулахгүй байх мөн тоосжилт үүсэхээс сэргийлэх талтай;
8. Газрын гадарга элэгдэл эвдрэлд өртсөнөөр хөрсөн бүрхэвч, ургамлын нөмрөг, хөрс шүтэн амьдрагч амьтны амьдрах орчин, аюулгүй байдал, агаарын тоосжилт гээд байгаль орчны бүрэлдэхүүн хэсгүүдэд шууд болон дам байдлаар нөлөөлөх
9. Төслийн үйл ажиллагаанаас шууд нөлөөлөлд өртөх газрын гадаргын шимт хөрсийг хуулж, MNS 5916:2008 стандартын дагуу хадгалах;
10. Ахуйн хаягдал, хогийн цэгийн ариутгал муугаас эвгүй үнэр гарах, шавж үржих
11. Хүчтэй салхи шуурга, түймэр, газар хөдлөл, аянга зэрэг байгалийн гамшгаас үүдэн аюул, осол гарах;
12. Санамсар, болгоомжгүйн улмаас гал алдах, түймэр гарах. Энэ тохиолдолд экосистем бүхэлдээ хэвийн үйл ажиллагаагаа алдах аюултай.
13. Техник-эдийн засгийн үндэслэл (ТЭЗҮ)-д хөдөлмөр аюулгүй байдлын талаар хангалттай тусгаж өгөөгүйгээс уурхайд осол аваар гарах, ажилчдын эрүүл мэндэд сөргөөр нөлөөлөх нөхцөл бүрдэх юм.

### ***Төслөөс газрын гадарга, хэвлийд нөлөөлөх байдал***

14. Уурхайн үйл ажиллагааны улмаас 2025 онд ил уурхай, барилга байгууламж, зам, хөрсний овоолго зэрэг нэмэлтээр 0.3 га талбайг хамарсан эвдрэл үүсч байгаль орчинд сөрөг нөлөө учруулна.
15. Ордыг ашигласнаар газрын гадаргууг өөрчлөхөөс гадна хөрсний бүтэц, дүүргийн гидрогеологийн горимыг өөрчилдөг.
16. Ил уурхайн аргаар ашигт малтмал, эрдэс түүхий эдийг олборлоход агаарт их хэмжээний тоос гарах нөхцөл бүрддэг. Бульдозер, ачигч зэрэг машин механизмуудаар хөрсийг хуулах овоолго хийх, түүхий эдийг бутлах, ачих зэрэг технологийн процессийн явцад салхитай нөхцөлд тоос ихээр гарч агаарыг бохирдуулах нөлөө үзүүлнэ.

### ***Хөрсний чанарт нөлөөлж болзошгүй сөрөг нөлөөлөл***

Төслийн үйл ажиллагаанаас хөрсөнд үзүүлэх сөрөг нөлөөллийг дурдвал:

- Ил уурхайн хил хязгаар дотор хайрга олборлоход “2025 оны ашиглалтын үйл ажиллагааны төлөвлөгөө” -ний тайланд тусгаснаар нийтдээ 0.3 га талбай нэмж эвдрэлд өртөж 35.06 мян.м<sup>3</sup> хөрс хуулна.
- Төслийн үйл ажиллагааны явцад машин механизмаас болон хүний анхаарал болгоомжгүй байдлаас шатахуун, тослох материал хөрсөнд ил задгай асгарч, хөрсийг бохирдуулах
- Уурхайд хөрсний овоолго хийх, нүүрс, хөрс тээвэрлэх зэрэг үндсэн үйл ажиллагаанд хүнд даацын олон машин ажиллахад хөрс их хэмжээгээр элэгдэл, эвдрэлд орж, хөрсний үржил шим алдагдана
- дайрга, хөрс тээвэрлэх явцад талбайд элдэв хог хаягдал бий болж ойр орчмын хөрсийг бохирдуулах, дагтаршсан шороон хэсэг суларч цас борооны усанд норж шавар шалбааг ихтэй, хуурай, салхитай үед тоос шороо босч орчныг бохирдуулах зэргээр нөлөөлнө.
- Хөрсний биологийн нөөц хомсдох, үржил шим нь алдагдах, хуурайших

### ***Усны чанарт нөлөөлж болзошгүй сөрөг нөлөөлөл***

- Одоогийн байдлаар “Цагаан давааны урд”-ын уурхайн гүн 7.0 м, хамгийн гүн хэсэгтээ +1267.1 м-ийн түвшинд олборлолт явагдана гэж тооцсон. 2025 онд газрын гүний усны нөөц, горимд сөрөг нөлөөлөл үзүүлэхээргүй байна.

- Аадар борооны үед тус талбайн хойд болон зүүн талаас түр зуурын үерийн ус бууж талбай дахь хөрс, элс, хатуу шингэн хог хаягдал, хагшаас зэргийг урсгаж гадаргын усыг бохирдуулж болзошгүй.
- Төслийн үйл ажиллагаанаас ахуйн болон үйлдвэрийн хог хаягдал хөрсийг бохирдуулснаас гадаргын болон гүний усанд шууд бусаар нөлөөлнө.
- Газар шорооны ажлын үед газрын доорх ус агуулсан үеийг ухаж хөндөх нь газрын доорх усыг бохирдуулах магадлалтай.

***Ургамлын зүйлийн бүрдэлд нөлөөлж болзошгүй сөрөг нөлөөлөл***

Төслийн үйл ажиллагаанаас дараах байдлаар ургамлын нөмрөгт нөлөөлнө. Үүнд:

1. Хог хаягдал салхиар дамжиж тархах болон хөрсөнд нэвчих байдлаар ургамал, хөрс, гүний усыг бохирдуулах нөхцөл болно,
2. Газар шорооны ажлын үед ургамлын үе хөрсийг хуулах,
3. Төслийн түүхий эд, материалыг зөөх тээвэрлэх,
4. Хөрс хуулах, хөрсний овоолго хийх,
5. Төслийн явцад бусад зориулалтаар газар ашиглахад ургамлын төрөл зүйл устаж үгүй болох, хувьсаж өөрчлөгдөх сөрөг нөлөөлөлтэй.

### *Төсөл хэрэгжих орчны амьтны аймагт нөлөөлөх нөлөөлөл*

Дайрганы ордыг ашиглах төсөл хэрэгжүүлэх хугацаанд хүн, машин техникийн дуу чимээ, хөдөлгөөн нэмэгдсэнээс үүсэх дуу чимээ болон чичиргээ доргилтоос тухайн нутгийн зэрлэг амьтдад шууд физик үйлчлэл, техногенезийн стресс үүсэх, бэлчээр, тэжээлийн хомсдол гарах зэрэг сөрөг нөлөөлөл үзүүлнэ. Дээрх төрлийн сөрөг нөлөөллөөс шалтгаалан орчны бүс дэх амьтад идээшсэн нутгаасаа дүрвэн зайлах, байршил нутгаа өөрчлөх зэрэг хариу үйлдэл гаргах бөгөөд энэ явцдаа олноор тэжээлийн хомсдол ба орчны өөрчлөгдлийн улмаас үхэж үрэгдэх, бусад махчин амьтдын идэш болох зэрэг зүй бус хорогдолд өртөж болзошгүй юм. Иймд төслийн талбайг эзэмших, уурхайн үндсэн ба туслах үйл ажиллагааг эхлэх хугацаа, горимыг дээрх нөхцөл байдалтай уялдуулан нарийн төлөвлөх, орон нутгийн ан амьтан хамгаалах, малчдын нөхөрлөл, санаачлагуудтай, шаардлагатай гэж үзвэл, мэргэжлийн байгууллагуудтай хамтарч уулын ажлын үед дагаж мөрдөх хамтарсан төлөвлөгөөтэй ажиллах шаардлагатай. Төслөөс үзүүлж болзошгүй сөрөг нөлөөлөл нь дараах хүчин зүйлсээр тодорхойлогдоно. Үүнд:

- Техникийн осол аваар
- Ухсан нүхэнд мал, амьтан унаж осолдох

Уурхайн үйл ажиллагааг зохион байгуулалттай явуулж, тээвэрлэлтийн замыг олон салаалуулалгүй, тэмдэг тэмдэглэгээгээр удирдан хязгаарлах нь нутгийн газар ба хөрс, ургамал, амьтдыг хамгаалах нэгэн төрлийн арга хэмжээ болно.

Хог хаягдал, ариун цэвэр бохирын асуудлыг сайтар төлөвлөхгүй бол хүнд ойромсог амьдардаг, хог хаягдлын индикатор гэгдэх зүйлүүдийн тоо өсөх магадлалтай

### *Төслөөс нийгэм, эдийн засгийн хөгжилд үзүүлэх нөлөөлөл*

Төслөөс нийгэм эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулахын тулд:

- Аюулгүй ажиллагааны дүрмийг баримтлах
- Ажилчдыг эрүүл мэндийн үзлэгт жил бүр хамруулах,
- Техник, тоног төхөөрөмжийн аюулгүй байдалд байнгын хяналт тавих
- Ажилчдын ажлын байрны аюулгүй орчныг бүрдүүлэх, хүнд нөхцөлд ажиллагсадад нэмэгдэл цалин, урамшуулал олгох
- Ажилчдын цалинг цаг тухай бүрт нь олгох зэрэг арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлнэ.

## 6. ЦАГААН ДАВАА БАРИЛГЫН ЧУЛУУ ОРДЫН УУРХАЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ, ҮНДСЭН ҮР ДҮН

Улаанбаатар хот Баянзүрх дүүрэг Цагаан даваа барилгын чулууны ордын уурхайн Байгаль орчны менежмент төлөвлөгөөний биелэлтийн тайланг боловсруулахдаа БОАЖЯ-ны сайдын 2019 оны 10 сарын 29-ны өдрийн А-618 тушаалаар батлагдсан “Байгаль орчны менежмент төлөвлөгөө боловсруулах, хянан батлах, тайлагнах журам”-ыг баримтлав. Түүний дагуу тухайн жилийн төлөвлөгөөнд тусгагдсан ажлуудын биелэлтийг нэг бүрчлэн тодорхойлж, хөрөнгө зардлыг тооцсон бөгөөд орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн биелэлтийн хэсэгт хяналт шинжилгээний ажлын үр дүнг дэлгэрэнгүй хэлбэрээр тусгасан болно.

2025 оны Цагаан давааны Барилгын чулууны ордын Байгаль орчны менежмент төлөвлөгөөний хүрээнд хэрэгжүүлсэн гол үйл ажиллагаанууд, түүний үр дүнг дурдвал:

- “Тэрбум мод” үндэсний хөтөлбөрийг дэмжих, мөн уурхайн үйл ажиллагаанаас үүсч болзошгүй ургамлан нөмрөгийн талхалалт болон тоосжилтыг бууруулах зорилгоор уурхайн хотхоны гадна болон дотоод талбайд 1 төрлийн нийт 20 ширхэг мод тарьсан.

- Цагаан давааны барилгын чулууны ордын уурхайн үйл ажиллагаанаас үүдэлтэй гол ба болзошгүй сөрөг нөлөөллийг хянах, бууруулах зорилгоор агаарын чанар, газрын доорх ус, хөрсөн бүрхэвч зэрэг чиглэлээр орчны хяналт шинжилгээний ажлуудыг хийж гүйцэтгэсэн.

Байгаль орчны менежмент төлөвлөгөөнд тусгагдсан ажлууд түүний биелэлтийн тоон үзүүлэлтийг дараах хүснэгтэнд нэгтгэн илэрхийлэв.

## 7. СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

Хүснэгт 6. Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт

№	Байгаль орчныг хамгаалах арга хэмжээ	Хамрах хүрээ	Ажлын гүйцэтгэл	Нийт зардал /мян.төг/	Биелэлтийн шалгуур
<b>Агаарын чанарт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах чиглэлээр</b>					
1	Ус шүршигч төхөөрөмжийн судалгаа хийх, тоосжилтын үүсвэрийг чийгшүүлэх	Төслийн талбай	Ус шүршигч төхөөрөмжийн судалгааг цахим сайтууд ашиглан хийсэн ба уурхайн дотоод зам талбайн усалгааг усны белазаар тогтмол хийж байна.	Үйл ажиллагааны зардлаас	Жилийн турш

2	Уурхайн үйл ажиллагаанаас үүдэлтэй тоосжилтыг дарах, хөрсийг бэхжүүлэх зориулалт бүхий замын тоос дарагч бодисын судалгааг хийх, тоосжилтын эх үүсвэрийг чийгшүүлэх	Төслийн талбай	Хөрс бэхжүүлэх, тоос дарагч бодисын судалгааг цахим сайт ашиглан хийсэн ба уурхайн дотоод зам талбайн усалгааг усны белазаар тогтмол хийж байна.	Үйл ажиллагааны зардлаас	Жилийн турш
<b>Усны нөөцөд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах чиглэлээр</b>					
3	Уурхайн шүүрлийн усыг ус шавхах хэмжээг хамгийн их байхаар сонгож ажиллах ба шавхсан усыг шавхан зайлуулах бөгөөд усыг автозамын усалгаанд ашиглах	Төслийн талбайд	Шүүрлийн усыг өдөр бүр 4-5 цагийн турш шавхан зайлуулдаг ба усыг зам, ногоон байгууламжийн усалгаанд ашиглаж байна.	Үйл ажиллагааны зардлаас	Тухай бүрт
<b>Газрын гадарга, хэвлийд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах чиглэлээр</b>					
6	ЗҮТ-с гарах хаягдал тосны хадгалалтанд хяналт тавьж шатах тослох материал алдагдаж болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлэх, машин техникийн бүрэн бүтэн байдлыг өдөр бүр шалгаж хөдөлгөөнд оролцуулах, шатах тослох материалаар бохирдсон тохиолдолд хөрсийг хуулан бохирдсон хөрсний овоолгод хүргэн саармагжуулах.	Уурхайн талбай	Өдөр бүр ажил эхлэхийн өмнө аюулгүй ажиллагааны зааварчилгаа өгч, техникийн бүрэн бүтэн байдлыг шалгадаг ба засвар үйлчилгээний төвийн үйл ажиллагаанаас шатах тослох материал хөрсөнд асгарсан тохиолдолд тэр даруй саармагжуулах, цэвэрлэх арга хэмжээ авч ажилладаг.	Үйл ажиллагааны зардлаас	Тухай бүрт
7	Уурхайн замын урсгал засваруудыг цаг тухайд нь хийх ба замгүй газраар буюу хөрсөн дээгүүр тээврийн хэрэгслүүд зорчих шаардлагатай болсон нөхцөлд зам засварын ажил	Уурхайн талбай	Уурхайн дотоод зам талбай болон нүүрс тээврийн замыг тогтмол хусаж сайжруулах ажлыг хийж гүйцэтгэсэн.	Үйл ажиллагааны зардлаас	Тухай бүрт

	дууссаны дараагаар шинээр зам гаргасан газрыг нөхөн сэргээж байгалийн унаган төрхөд нь ойртуулах				
<b>Хөрсөн бүрхэвч, ургамлан нөмрөгт үзүүлэх сөрөг нөлөөллийг буруулах чиглэлээр</b>					
8	Ил уурхайг олборлох явцад хуулсан шимт хөрсийг стандартын дагуу хадгалж, овоолго үүсгэн салхинд хийсэх, усанд автах, хаягдал чулуулгийн овоолго болон бусад материалаар бохирдохоос хамгаалах	Шимт хөрсний овоолго	Монгол Улсын стандарт MNS 5916:2008 газар шорооны ажлын үед үржил шимт хөрс хуулалт, хадгалалтын дагуу шимт хөрсний овоолгыг үүсгэсэн. Уул уурхай, үйлдвэрлэлийн үйл ажиллагаа явуулахаас өмнө хөрсний үе давхаргын зузааныг тодорхойлж, харилцан адилгүй тогтоосон гүн хүртэл шимт хөрсийг хуулж хадгалж, чанарын хяналт хийж гүйцэтгэв.	Үйл ажиллагааны зардлаас	Жилийн турш
9	Засвар үйлчилгээний үед гарсан аюултай хог хаягдал асгарч хөрсөн бүрхэвчийг бохирдуулсан тохиолдолд богино хугацаанд хөрсөн бүрхэвчийг хуулж бохирдсон хөрсний овоолгод байршуулж саармагжуулах, шаардлагатай багаж хэрэгслээр тоноглон байх.	Үйлчилгээний талбайд	Засвар үйлчилгээний төвийн үйл ажиллагаанаас гарсан аюултай хог хаягдыг зориулалтын бэлтгэсэн талбайд хадгалан бүртгэл хөтөлдөг. Мөн хөрсөнд асгарсан тохиолдолд тэр даруй хусаж цэвэрлэн, бэлтгэсэн цементэн талбайд саармагжуулах арга хэмжээ авч ажилладаг.	Үйл ажиллагааны зардлаас	Тухай бүр
<b>Амьтны аймагт үзүүлэх сөрөг нөлөөллийг буруулах чиглэлээр</b>					
<b>Нийт зардал, мян.төг</b>				-	

Өдөр бүр ажил эхлэхийн өмнө аюулгүй ажиллагааны зааварчилгаа өгч, техникийн бүрэн бүтэн байдлыг шалгадаг ба засвар үйлчилгээний төвийн үйл ажиллагаанаас шатах тослох материал хөрсөнд асгарсан тохиолдолд тэр даруй цэвэрлэх, саармагжуулах арга хэмжээ авч, хөдөлмөр хамгааллын хэрэгсэл, саармагжуулах бодисыг бэлэн байлгадаг.



Зураг 5. Хөдөлмөр хамгааллын хэрэгсэл болон бохирдсон хөрс саармагжуулах бодис

**7.1** ЗҮТ-с гарах хаягдал тосны хадгалалтанд хяналт тавьж шатах тослох материал алдагдаж болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлэх, машин техникийн бүрэн бүтэн байдлыг өдөр бүр шалгаж хөдөлгөөнд оролцуулах, шатах тослох материалаар бохирдсон тохиолдолд хөрсийг хуулан бохирдсон хөрсний овоолгод хүргэн саармагжуулах

**7.2** Уурхайн замын урсгал засваруудыг цаг тухайд нь хийх ба замгүй газраар буюу хөрсөн дээгүүр тээврийн хэрэгслүүд зорчих шаардлагатай болсон нөхцөлд зам засварын ажил дууссаны дараагаар шинээр зам гаргасан газрыг нөхөн сэргээж байгалийн унаган төрхөд нь ойртуулах

Уурхайн дотоод зам талбай болон уурхайгаас Могойн гол хүртлэх 39км нүүрс тээврийн замыг өөрсдийн техник болох автогрейдер, хово автосамосвал, ачигч зэрэг техникүүдээр тогтмол хусаж сайжруулдаг ба олон салаа зам гаргахаас урьдчилан сэргийлж замын хажуугаар шуудуу далан үүсгэсэн.

**7.3** Ил уурхайг олборлох явцад хуулсан шимт хөрсийг стандартын дагуу хадгалж, овоолго үүсгэн салхинд хийсэх, усанд автах, хаягдал чулуулгийн овоолго болон бусад материалаар бохирдохоос хамгаалах

Монгол Улсын стандарт MNS 5916:2008 газар шорооны ажлын үед үржил шимт хөрс хуулалт, хадгалалтын дагуу шимт хөрсний овоолгыг үүсгэсэн. Уул уурхай, үйлдвэрлэлийн үйл ажиллагаа явуулахаас өмнө хөрсний үе давхаргын зузааныг тодорхойлж, харилцан адилгүй тогтоосон гүн хүртэл шимт хөрсийг хуулж хадгалж, чанарын хяналт хийж гүйцэтгэв.



Зураг 9. Шимт хөрсний овоолго үүсгэсэн байдал

**7.4 Засвар үйлчилгээний үед гарсан аюултай хог хаягдал асгарч хөрсөн бүрхэвчийг бохирдуулсан тохиолдолд богино хугацаанд хөрсөн бүрхэвчийг хуулж бохирдсон хөрсний овоолгод байршуулж саармагжуулах, шаардлагатай багаж хэрэгслээр тоногложсон байх**

Засвар үйлчилгээний төвийн үйл ажиллагаанаас гарсан аюултай хог хаягдыг зориулалтын бэлтгэсэн талбайд хадгалан бүртгэл хөтөлдөг. Тайлант онд засвар үйлчилгээний төвийн үйл ажиллагаанаас асгаралт үүсээгүй.

**7.5 Уурхай орчмын барилга байгууламжуудыг тойруулан хашсан торон хашааны бүрэн бүтэн байдлыг тогтмол шалгах ба нурж эвдэрсэн тохиолдолд засаж мал, амьтан нэвтрэхгүй байх нөхцөлийг бүрдүүлэх**

Барилга байгууламжийг тойруулан хашсан хашааны бүрэн бүтэн байдал, уурхайн талбай, ногоон байгууламжид мал орохоос сэргийлж уулын мастер, аж ахуйн ажилтнууд байнгын хяналт тавьж ажилладаг.

## 8. НӨХӨН СЭРГЭЭХ АЖЛЫН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

2025 онд уурхайн техникийн нөхөн сэргээлтийн ажилд нийт 4200.0 мян.төг төлөвлөсөн. Техникийн нөхөн сэргээлтийг Монгол улсын Байгаль орчин, ногоон хөгжил, аялал жуулчлалын сайдын 2015 оны 03 дугаар сарын 30 –ны өдрийн А-138 дугаар тушаал “Уул уурхайн үйл ажиллагааны улмаас эвдрэлд орсон газарт техникийн болон биологийн нөхөн сэргээлт хийх аргачлал” -ын дагуу гүйцэтгэж нөхөн сэргээлтэнд гарах зардлыг Байгаль орчин, аялал жуулчлалын яамны сайд, Эрдэс баялаг, эрчим хүчний яамны сайдын хамтарсан 2010 оны 05 сарын 17-ны өдрийн А-132/112 дугаар тушаалын хавсралтын дагуу хийж гүйцэтгэнэ.

Нөхөн сэргээлтийн ажилд дараах стандарт болон заавруудын шаардлагыг хангах:

- MNS 5915:2008 Уул уурхайн үйлдвэрлэлийн үйл ажиллагаагаар эвдэрсэн газрын ангилал
- MNS 5917:2008 Уул уурхайн үйлдвэрлэлийн үйл ажиллагаагаар эвдэрсэн газрын нөхөн сэргээлт. Техникийн шаардлага
- MNS 4915:2000 Ашигт малтмал эрж хайх явцад эвдэрсэн газрын нөхөн сэргээлт. Техникийн шаардлага
- MNS 5916:2008 Газар шорооны ажлын үед үржил шимт хөрсийг хуулах, Хадгалах. Техникийн шаардлага
- MNS 4920:2000 Эвдэрсэн газрын хажуугийн налуу. Техникийн шаардлага
  - Ашигт малтмал эрж хайх ажлын явцад эвдэрсэн газрыг нөхөн сэргээж ургамалжуулах заавар (БО -ны болон ХААҮ -ийн сайдын 2000 оны 64/А/62 тоот тушаалын 3-р хавсралт)

№	Нөхөн сэргээлтийн зорилт	Нөхөн сэргээлтийн арга хэмжээ	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Нэгжйн зардал, мян.төг	Нийт зардал, мян.төг	Хэрэгжүүлэх хугацаа	Баримтлах эрх зүйн баримт бичиг
1	Техникийн нөхөн сэргээлт	Тэгшилгээ, хэлбэржүүлэлт дүүргэлт	Мян.м <sup>3</sup>	30.5	4200	4200	9-10 сард	1.106 <sup>0</sup> 33 <sup>1</sup> 59.0 <sup>II</sup> 47 <sup>0</sup> 48 <sup>1</sup> 59.1 <sup>II</sup> 2.106 <sup>0</sup> 34 <sup>1</sup> 0.0 <sup>II</sup> 47 <sup>0</sup> 48 <sup>1</sup> 58 <sup>II</sup> 3.106 <sup>0</sup> 34 <sup>1</sup> 0.0 <sup>II</sup> 47 <sup>0</sup> 48 <sup>1</sup> 58 <sup>II</sup> 4.106 <sup>0</sup> 33 <sup>1</sup> 59.0 <sup>II</sup> 47 <sup>0</sup> 48 <sup>1</sup> 59.1 <sup>II</sup>  MNS 4915:2000 Ашигт малтмал ашиглах явцад эвдэрсэн газрын нөхөн сэргээлт, Техникийн шаардлага, MNS 4920:2000 Эвдэрсэн газрын хажуугийн налуу. Техникийн шаардлага
	<b>Нийт</b>					<b>4200.0</b>		

*Хүснэгт 7. Нөхөн сэргээх ажлын төлөвлөгөөний биелэлт*

№	Байгаль орчныг хамгаалах арга хэмжээ	Хамрах хүрээ	Ажлын гүйцэтгэл	Нийт зардал /мян.төг/	Биелэлтийн шалгуур
1	Уурхайн байгаль орчныг хамгаалах нөхөн сэргээх зардлыг тусгай дансанд байршуулах	Уурхайн хэмжээнд	Уурхайн байгаль орчныг хамгаалах нөхөн сэргээх зардлыг БОАЖЯ-ны тусгай дансанд байршуулсан.	10500 000	Тухайн жилдээ
2	Уурхайн суурингийн ногоон байгууламжийг арчлан тордож, ногоон байгууламжийг нэмэгдүүлэх	Уурхайн талбайд	2025 оны 6 дугаар сараас ногоон байгууламжийн усалгааг эхлүүлсэн ба уурхайн кемпийн хэсэгт 250 ширхэг мод тарьж арчилгаа, усалгааг өдөр бүр хийж гүйцэтгэсэн.	4500.000	Тухайн жилдээ
<b>Нийт зардал</b>				<b>15 000 000</b>	

**8.1 Уурхайн байгаль орчныг хамгаалах нөхөн сэргээх зардлыг тусгай дансанд байршуулах**

Уурхайн байгаль орчныг хамгаалах нөхөн сэргээх зардал болох 10 500 000 төгрөгийг БОАЖЯ-ны тусгай дансанд байршуулсан.

**8.2 Уурхайн суурингийн ногоон байгууламжийг арчлан тордож, ногоон байгууламжийг нэмэгдүүлэх**

2026 оны 6 дугаар сараас ногоон байгууламжийн усалгааг эхлүүлсэн ба уурхайн хотхоны өргөтгөл болон нөхөн тарилтаар 1 төрлийн нийт 250 ширхэг мод тарьж арчилгаа, усалгааг өдөр бүр хийж гүйцэтгэсэн.

## 9. БИОЛОГИЙН ОЛОН ЯНЗ БАЙДЛЫГ ДҮЙЦҮҮЛЭН ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

Хүснэгт 8. Биологийн олон янз байдлыг дүйцүүлэн хамгаалах  
арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт

№	Байгаль орчныг хамгаалах арга хэмжээ	Хамрах хүрээ	Ажлын гүйцэтгэл	Нийт зардал /мян.төг/	Биелэлтийн шалгуур
1	Тэгш газар ХХК-аар	Баянзүрх дүүргийн 3 хорооны нийтийн эзэмшлийн 866 мкв	Сайхны булаг нэртэй газрын хамгаалалтын хашаа, торыг гагнаж янзалсан.	7 500 000	Тухайн жилдээ
<b>Нийт зардал</b>				<b>7 500 000</b>	

Биологийн олон янз байдлыг дүйцүүлэн хамгаалах ажлын хүрээнд Баянзүрх дүүргийн 3 хорооны нутаг дэвсгэрт улсын 2 дугаар эмнэлэгийн зүүн талд 866мкв бүхий талбайг зүлэгжүүлж 270 ширхэг мод тарьсан.

## НҮҮЛГЭН ШИЛЖҮҮЛЭХ, НӨХӨН ОЛГОВОР ОЛГОХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

Уурхайн нөлөөллийн бүсэд нүүлгэн шилжүүлэх асуудлыг байхгүй

## 10. ТҮҮХ, СОЁЛЫН ӨВИЙГ ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

Төсөл хэрэгжих бүс нутаг, түүний орчимд түүх, соёлын өв дурсгалууд илрээгүй тул арга хэмжээ төлөвлөөгүй болно.

## 11. ОСОЛ ЭРСДЭЛИЙН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

Хүснэгт 10. Осол эрсдэлийн менежментийн төлөвлөгөөний биелэлт

№	Урьдчилан сэргийлэх, хамгаалах арга хэмжээ	Хамрах хүрээ	Ажлын гүйцэтгэл	Нийт зардал /мян.төг/	Биелэлтийн шалгуур
1	Технологийн хэвийн ажиллагааны горим алдагдах, тоног төхөөрөмжүүдэд эвдрэл, доголдол гарахаас урьдчилан сэргийлж үзлэг оношилгоог	Уурхайн хэмжээнд	Үзлэг оношлигоог тогтмол хийж эвдрэл гэмтэл гарсан тохиолдолд засварлаж байна.	Үйл ажиллагааны зардлаас	Жилийн турш

	ТОГТМОЛ хийх, байнгын хяналт тавих				
2	Уурхайн цахилгаан тоног төхөөрөмж, өндөр хүчдэл зэрэгтэй харьцан ажиллаж буй хүн мэргэжлийн хүн байх, мэргэжлийн бус хүн түүгээр оролдох, харьцаж ажиллахыг хатуу хориглох	Нийт ажилтан	Цахилгааны эвдрэл гэмтлийг цахилгааны инженер, цахилгаанчин, диспичерүүд засаж байна.	Үйл ажиллагааны зардлаас	Жилийн турш
3	Мэргэшиж дадаагүй ажилчдыг удирдлагын заавар, зөвшөөрөлгүй, бусдын гуйлт хүсэлтээр буюу дур мэдэн ажил гүйцэтгүүлэхгүй байх, осол аваар гарахаас урьдчилан сэргийлэх	Нийт ажилтан	Ажил эхлэхээс өмнө ажилчдын хийх ажил болон аюулгүй ажиллагааны зааварчилгааг өгдөг.	Үйл ажиллагааны зардлаас	Жилийн турш
4	Өндөр хүчдэл, цахилгаан тоног төхөөрөмжтэй харьцан ажиллаж буй хүнийг багаж хэрэгсэл, хамгааллын хувцсаар бүрэн хангах, хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааны дүрмийг чанд мөрдүүлэн ажиллах	Нийт ажилтан	Цахилгаанчин, диспичерүүдэд ажил эхлэхээс өмнө хөдөлмөрийн аюулгүй байдал, аюулгүй ажиллагааны зааварчилгаа өгч, хувцас хэрэгслээр ханган аюулгүй ажиллагаанд байнгын хяналт тавьж ажилласан.	Үйл ажиллагааны зардлаас	Жилийн турш
5	Чийгтэй орчинд цахилгаан тоног төхөөрөмж, өндөр хүчдэлтэй харьцан ажиллавал богино	Нийт ажилтан	Хур тунадас орсон үед цахилгаан тоног төхөөрөмжтэй харьцах ажлыг зогсоодог.	Үйл ажиллагааны зардлаас	Жилийн турш

	холбоо үүсэх эрсдэлтэй тул урьдчилан сэргийлэх үүднээс хур тунадас, чийгтэй үед ажилчдыг ажиллуулахгүй байх				
6	Цахилгаан хэрэгслийн хүчдэлийг салгалгүй засвар үйлчилгээ хийж хүчдэлд цохиулахаас байнга урьдчилан сэргийлэх	Нийт ажилтан	Тоног төхөөрөмж болон удирдлагын самбарыг хүчдэлгүй болгон ажлын байр бэлдэж хүчдэлд цохиулахаас урьдчилан сэргийлсэн.	Үйл ажиллагааны зардлаас	Жилийн турш
7	Цахилгаан тоног төхөөрөмжид байнгын үзлэг үйлчилгээ хийх, ашиглалтын заавар зөрчихгүй байх	Нийт ажилтан	Цахилгаанчин 1,2-р шатны үзлэг болон 04кВ-ын үзлэгийг өдөр тутам, цахилгааны инженер 3,4-р шатны үзлэгийг сард 2 удаа хийсэн.	Үйл ажиллагааны зардлаас	Жилийн турш
8	Аюулгүйн зайлшгүй буюу мэдээжийн арга хэмжээ авалгүй эсвэл аваагүй байхад ажилд яаравчлан орохгүй байх, хөдөлмөр хамгаалал аюулгүй ажиллагааны дүрэм, зааврыг мөрдөн ажиллах	Нийт ажилтан	Аливаа эрсдэлээс урьдчилан сэргийлж ажил эхлэхийн өмнө аюулгүй ажиллагааны зааварчилгаа, дүрмийг танилцуулан, хэрэгжилтэнд байнгын хяналт тавьж ажилласан.	Үйл ажиллагааны зардлаас	Жилийн турш
9	Өндөр даралт, температур, хүчдэлийг бүрэн буусан эсэхийг байнга шалган магадлах, түүний үндсэн дээр ажилд орох, завсар үйлчилгээ хийх	Нийт ажилтан	Удирдлагын хэлхээг салгаж ажлын байр бэлдэж зөөврийн болон тоноглолын газардуулгыг тавьсны дараагаар ажлыг эхлүүлдэг.	Үйл ажиллагааны зардлаас	Жилийн турш
<b>Нийт зардал</b>				<b>1500 000</b>	

**11.1 Технологийн хэвийн ажиллагааны горим алдагдах, тоног төхөөрөмжүүдэд эвдрэл, доголдол гарахаас урьдчилан сэргийлж үзлэг оношилгоог тогтмол хийх, байнгын хяналт тавих**

Уурхайн тоног төхөөрөмжүүдэд хариуцсан инженер техникийн ажилчид байнгын хяналт тавин ажилладаг.

**11.2 Уурхайн цахилгаан тоног төхөөрөмж, өндөр хүчдэл зэрэгтэй харьцан ажиллаж буй хүн мэргэжлийн хүн байх, мэргэжлийн бус хүн түүгээр оролдох, харьцаж ажиллахыг хатуу хориглох**

Цахилгааны эвдрэл гэмтлийг цахилгааны инженер, цахилгаанчин, диспичерүүд хариуцан засах ба Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн анхан болон давтан зааварчилгаагаар мэргэжлийн бус хүн цахилгаан, өндөр хүчдэлтэй харьцан ажиллахыг хориглох талаар сургалтыг нийт ажилчдад орж танилцуулдаг.

**11.3 Мэргэшиж дадаагүй ажилчдыг удирдлагын заавар, зөвшөөрөлгүй, бусдын гуйлт хүсэлтээр буюу дур мэдэн ажил гүйцэтгүүлэхгүй байх, осол аваар гарахаас урьдчилан сэргийлэх**

Өдөр бүр ажил эхлэхийн өмнө нийт ажилчид аюулгүй ажиллагааны нярад авч ажил үүргээ гүйцэтгэдэг ба тайлант онд ажлын байран дахь осол, гэмтэл бүртгэгдээгүй болно.



Зураг 17. Цахилгаан, механик, уулын хэсгийн аюулгүй ажиллагаа, ажлын нярад өгсөн байдал

**11.4 Өндөр хүчдэл, цахилгаан тоног төхөөрөмжтэй харьцан ажиллаж буй хүнийг багаж хэрэгсэл, хамгааллын хувцсаар бүрэн хангах, хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааны дүрмийг чанд мөрдүүлэн ажиллах**

Цахилгаанчин, диспичерүүдэд ажил эхлэхээс өмнө хөдөлмөрийн аюулгүй байдал, аюулгүй ажиллагааны зааварчилгаа өгч, хувцас хэрэгслээр ханган аюулгүй ажиллагаанд байнгын хяналт тавьж ажилласан.

**11.5 Чийгтэй орчинд цахилгаан тоног төхөөрөмж, өндөр хүчдэлтэй харьцан ажиллавал богино холбоо үүсэх эрсдэлтэй тул урьдчилан сэргийлэх үүднээс хур тунадас, чийгтэй үед ажилчдыг ажиллуулахгүй байх**

Хур тунадас орсон үед цахилгаан тоног төхөөрөмжтэй харьцах ажлыг зогсоодог.

**11.6 Цахилгаан хэрэгслийн хүчдэлийг салгалгүй засвар үйлчилгээ хийж хүчдэлд цохиулахаас байнга урьдчилан сэргийлэх**

Тоног төхөөрөмж болон удирдлагын самбарыг хүчдэлгүй болгон ажлын байр бэлдэж хүчдэлд цохиулахаас урьдчилан сэргийлдэг ба үүнд ХЭМАБ инженер, цахилгааны инженер хяналт тавин ажилладаг.

**11.7 Цахилгаан тоног төхөөрөмжид байнгын үзлэг үйлчилгээ хийх, ашиглалтын заавар зөрчихгүй байх**

Цахилгаанчин 1,2-р шатны үзлэг болон 04кВ-ын үзлэгийг өдөр тутам, цахилгааны инженер 3,4-р шатны үзлэгийг сард 2 удаа хийсэн.

**11.8 Аюулгүйн зайлшгүй буюу мэдээжийн арга хэмжээ авалгүй эсвэл аваагүй байхад ажилд яаравчлан орохгүй байх, хөдөлмөр хамгаалал аюулгүй ажиллагааны дүрэм, зааврыг мөрдөн ажиллах**

Уурхайн нийт ажилчдад MNS4969:2000 стандарт болон Хөдөлмөр нийгмийн хамгааллын сайдын 2019 оны А/370 тоот тушаалын дагуу ХАБЭА-н сургалт, зааварчилгааг байнга ордог. Үүнд:

*Хүснэгт 11. ХАБЭА-н чиглэлээр ордог сургалт, түүний давтамж*

№	ХАБЭА зааварчилга	Давтамж	
1	Урьдчилсан зааварчилгаа	Шинэ ажилчдад	
2	Ажлын байран дахь анхан шатны зааварчилгаа	Шинэ болон ажлын байрны нөхцөл өөрчлөгдсөн ажилчдад	
3	Давтан зааварчилгаа	Ээлжит	Улирал тутам
4		Ээлжит бус	Тухай бүрт
5		Өдөр тутмын	Өдөр бүр
6	Шинэ ажилтны сургалт	Шинэ ажилчдад	
7	Нийт ажилтны сургалт	Жилд 2 удаа	
8	Ажил олгогчийн сургалт	Жилд 1 удаа	
9	Эрсдэлтэй ажлын байрны сургалт	2 жилд 1 удаа	
10	Тусгай сургалт	Тухай бүрт	

Тайлант онд нийт 1 удаагийн багц сургалтанд давхардсан тоогоор 25 ажилтан хамрагдсан байна.



Зураг 20. ХАБЭА-н сургалт орж байгаа нь

### 11.9 Өндөр даралт, температур, хүчдэлийг бүрэн буусан эсэхийг байнга шалган магадлах, түүний үндсэн дээр ажилд орох, завсар үйлчилгээ хийх

Удирдлагын хэлхээг салгаж ажлын байр бэлдэж зөөврийн болон тоноглолын газардуулгыг тавьсны дараагаар ажлыг эхлүүлдэг. Дээрх ажил гүйцэтгэх явцад ХЭМАБ инженер, цахилгааны инженер байнгын хяналт тавин, аюулгүй ажиллагааны заавраар ханган ажилладаг.

## 12. ХОГ ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

Хүснэгт 12. Хог хаягдлын менежментийн төлөвлөгөөний биелэлт

№	Байгаль орчныг хамгаалах арга хэмжээ	Хамрах хүрээ	Ажлын гүйцэтгэл	Нийт зардал /мян.төг/	Биелэлтийн шалгуур
1	Энгийн хог хаягдлаа ангилан ялгах, хог хаягдлын цэгийг стандарт шаардлагын дагуу байгуулах, шаардлага хангасан ангилан ялгах хогийн сав байршуулах	Уурхайн хэмжээнд	Хог хаягдал ангилан ялгах хогийн цэг байгуулсан.	Үйл ажиллагааны зардлаас	Жилдээ
2	Хог хаягдал цуглуулах, тээвэрлэх эрх бүхий аж ахуйн нэгж, байгууллагатай хог тээврийн үйлчилгээний гэрээ байгуулах, үүссэн хог хаягдлаа тогтмол зайлуулах		2025 оны 1 дүгээр сард Баянзүрх дүүрэгтэй хог хаягдлын гэрээг байгуулан үүссэн хог хаягдлаа сумын төвийн хогийн цэгт хаяж байна.	860 000	Жилдээ
3	Ажилчдад хог хаягдлыг бууруулах, ангилах, дахин ашиглах, зүй зохистой хаях дадал		Уурхайн 1 болон 2-р ээлжний ажилчдад хог хаягдлын ангилан ялгалт, менежментийн	Үйл ажиллагааны зардлаас	Жилдээ

	зуршлыг хэвшүүлэх, сургалт зохион байгуулах		тухай сургалтыг зохион байгуулсан.		
4	Үүсэх хог хаягдлыг ангилан ялгах, хог хаягдал цуглуулах, тээвэрлэх, дахин боловсруулах, сэргээн ашиглах, шатаах, устгахдаа үйл ажиллагаатай холбоотой хяналт тавих		Уурхайн хэмжээнд мөрдөх Хог хаягдлын журам, процессын зураглалыг уурхайн даргаар батлуулан журмын хэрэгжилт, хог хаягдлын менежментийн хэрэгжилтэнд байнгын хяналт тавин ажиллаж байна.	Үйл ажиллагааны зардлаас	Тухай бүр
5	Тос тосолгооны материалын үлдэгдэл хаягдлыг ил задгай хаяхгүй байх, тусгай талбайд зориулалтын битүүмжлэлтэй цэгт хуримтлуулах		Хаягдал тос маслыг зориулалтын бэлтгэсэн талбайд хадгалж, бүртгэл хөтөлж байна.	Үйл ажиллагааны зардлаас	Жилдээ
<b>Нийт зардал</b>				<b>860 000</b>	

**12.1 Энгийн хог хаягдлаа ангилан ялгах, хог хаягдлын цэгийг стандарт шаардлагын дагуу байгуулах, шаардлага хангасан ангилан ялгах хогийн сав байршуулах**

Уурхайн хэмжээнд хог хаягдлын хэмжээг бууруулах, дахин ашиглах боломжийг нэмэгдүүлэх зорилгоор хог хаягдлыг ангилан ялгаж түр хадгалах цэгийг ахуйн, дахивар, бусад гэсэн 3 хэсэгт хуваан байгуулсан.

**12.2 Ажилчдад хог хаягдлыг бууруулах, ангилах, дахин ашиглах, зүй зохистой хаях дадал зуршлыг хэвшүүлэх, сургалт зохион байгуулах**

Уурхайн нийт ажилчдад байгаль орчны бохирдлоос урьчдиглан сэргийлэх, үүсч буй хог хаягдлаа хэрхэн ангилан ялгах талаар мэдлэг олгох, уурхайн даргын баталсан “Хог хаягдлын менежментийн журам” танилцуулах зорилгоор сургалтыг зохион байгуулан хэрэгжилтэнд байнгын хяналт тавин ажиллаж байна.

### 13. ОРЧНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨРИЙН БИЕЛЭЛТ

#### 13.1 Ус, хөрсний хяналт шинжилгээ

*Хүснэгт 14. Усны хяналт шинжилгээний биелэлт*

№	Байгаль орчныг хамгаалах арга хэмжээ	Хамрах хүрээ	Ажлын гүйцэтгэл	Нийт зардал /мян.төг/	Биелэлтийн шалгуур
1	Ca, Mg, CL, SO4, NO2, K агууламж, амт, үнэр, өнгө, рН нийт ууссан хатуу бодисын хэмжээ, нийт хатуулаг	Унд, шүүрлийн ус	Унд, шүүрлийн уснаас дээж авч Дундговь аймгийн УЦУОШТөвийн байгаль орчны шинжилгээний лабораториор химийн шинжилгээг гүйцэтгүүлсэн.	500 000	Жилд 1 удаа
2	Хөрсний шинжилгээ	Хөрс	3н дээж	500 000	Жилд 1 удаа
<b>Усны хяналт шинжилгээний хөтөлбөрийн нийт зардал</b>				<b>1000 000</b>	

Уурхайн ундны уснаас 6, 10-р сард дээж авч итгэмжлэгдсэн Усны төв лаборатори, Ханлаб ХХК-ийн лабораторид химийн шинжилгээг хийлгүүлэв. Шинжилгээний дүнг MNS0900:2018 “Ундны ус, эрүүл ахуйн шаардлага” стандарттай харьцууллаа.

Хөрсний дээж 3 удаа авч MNS5850:2019 “Хөрс бохирдуулагч бодис элементүүдийн зөвшөөрөгдөх дээд хэмжээ” стандарттай харьцуулалаа.

## 14. УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

*Хүснэгт 25. Удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөөний биелэлт*

№	Байгаль орчныг хамгаалах арга хэмжээ	Хамрах хүрээ	Ажлын гүйцэтгэл	Нийт зардал мян.төг	Биелэлтийн шалгуур
1	Байгаль орчны менежментийн төлөвлөгөөг боловсруулан холбогдох газраар батлуулж, биелэлтийг хангах	Уурхайн хэмжээнд	2025 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөөг боловсруулан БОАЖЯ-р батлуулан, биелэлтийг ханган ажилласан.	Үйл ажиллагааны зардлаас	Хуваарийн дагуу хийх
2	Төслийн хэмжээнд бүхэлд нь Гамшгийн эрсдэлийн үнэлгээг Онцгой байдлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагаас тусгай зөвшөөрөл авсан эрх бүхий мэргэжлийн байгууллагаар хийлгэж, гамшгаас хамгаалах төлөвлөгөө боловсруулан, батлан хэрэгжүүлэх		Уурхайн гамшгаас хамгаалах төлөвлөгөөг хийлгэж батлуулсан.	Үйл ажиллагааны зардлаас	
3	Байгаль орчны сургалт семинарыг зохион байгуулж, түүнд хамруулах		Байгаль орчны сургалтыг нийт ажилчдад орсон.	Үйл ажиллагааны зардлаас	
4	Харилцаа мэдээлэл /янз бүрийн түвшин ба ажил үүргийн хоорондын дотоод харилцаа мэдээлэл, гаднын сонирхогч талуудаас ирүүлсэн холбогдох харилцаа мэдээллийг хүлээн авах, баримтжуулах ба түүнд хариу өгөх/		Уурхайд ирсэн албан бичгүүдийг хүлээн авч биелэлтийг ханган шийдвэрлэсэн.	Үйл ажиллагааны зардлаас	
5	Байгаль орчны суурь нөхцөлд өөрчлөлт гарсан		Ус, хөрс, агаарын чанарт хяналт тавьж, шинжилгээнүүдийг хийлгэсэн.	Үйл ажиллагааны зардлаас	

	эсэхэд хяналт тавьж, хэмжилт хийх		
6	Байгаль орчны суурь нөхцөл нь стандарт шаардлагад нийцэж байгаа эсэхийг тодорхойлох	Ус, хөрс, агаарын чанар стандартад нийцэж байгаа эсэхийг тодорхойлсон.	Үйл ажиллагааны зардлаас
7	Байгаль орчны судалгаа үнэлгээ, хяналттай холбоотой бүртгэлийн хяналтыг байнга хөтлөх	Аймаг, сумаас ирсэн хяналт шалгалтын бүртгэл хөтөлсөн.	Үйл ажиллагааны зардлаас
<b>Нийт зардал</b>			-

**14.1 Байгаль орчны менежментийн төлөвлөгөөг боловсруулан холбогдох газраар батлуулж, биелэлтийг хангах**

2025 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөөг боловсруулан БОАЖЯ-р батлуулан, биелэлтийг ханган ажилласан.

**14.2 Мэргэжлийн байгууллагатай хамтран хог хаягдлыг тээвэрлэн, зайлуулах гэрээг хийж, гүйцэтгэлийг хангах**

Уурхайн хог хаягдлын гэрээг Баянзүрх дүүрэг, татварын газартай Злсан гэрээ байгуулсан 860,000 төгрөгийн төлбөрийг төлсөн.

**15.3 Төслийн хэмжээнд бүхэлд нь Гамшгийн эрсдэлийн үнэлгээг Онцгой байдлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагаас тусгай зөвшөөрөл авсан эрх бүхий мэргэжлийн байгууллагаар хийлгэж, гамшгаас хамгаалах төлөвлөгөө боловсруулан, батлан хэрэгжүүлэх**

Уурхайн гамшгаас хамгаалах төлөвлөгөөг хийлгэж аймгийн Онцгой байдлын газраар батлуулсан.

**15.4 Байгаль орчны сургалт семинарыг зохион байгуулж, түүнд хамруулах**

Уурхайн нийт ажилчдад 1 удаагийн багц сургалтыг усны менежмент, хог хаягдлын ангилан ялгалт, хөрсний бохирдол, ургамал, амьтан хамгаалал, компани болон уурхайн дотоод журам зэрэг сэдвүүдийн хүрээнд орсон.

**15.5 Харилцаа мэдээлэл /янз бүрийн түвшин ба ажил үүргийн хоорондын дотоод харилцаа мэдээлэл, гаднын сонирхогч талуудаас ирүүлсэн холбогдох харилцаа мэдээллийг хүлээн авах, баримтжуулах ба түүнд хариу өгөх/**

Уурхайд хэмжээнд дотоод болон гадны байгууллагаас ирүүлсэн албан бичиг, хүсэлтүүдийг хүлээн авч биелэлтийг ханган, хариу хүргүүлсэн.

**15.6 Байгаль орчны суурь нөхцөлд өөрчлөлт гарсан эсэхэд хяналт тавьж, хэмжилт хийх**

Ус, хөрсний чанарт уурхайн үйл ажиллагаанаас үзүүлж буй нөлөөллийг хянах зорилгоор жилд 1 удаа дээж авч, итгэмжлэгдсэн лабораториор шинжилгээ хийлгэсэн. /Шинжилгээний дүнг орчны хяналт шинжилгээний хөтөлбөр хэсгээс харна уу/

**16 БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨГ ХЭРЭГЖҮҮЛЭХЭД  
ГАРСАН НИЙТ ЗАРДЛЫН ХЭМЖЭЭ**

2025 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний зардалд 20938.0 мян. төгрөг төлөвлөн тусгаж гүйцэтгэлээр 30060.0 мян төгрөг зарцуулсан.

*Хүснэгт 26. Нийт зардлын хэмжээ*

№	Хийгдэх ажлын чиглэл	Хийгдсэн ажлын тодорхойлолт	Зарцуулалт, мян.төг
1	Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төсөв	Уурхайн сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээ	-
2	Нөхөн сэргээлт	Барьцаа хөрөнгө байршуулах, хотхоны ногоон байгууламж нэмэгдүүлэх	19200.0
3	Дүйцүүлэн хамгаалах үйл ажиллагаа	Орон нутгийн саналын дагуу	7500 000
4	Нүүлгэн шилжүүлэлт, нөхөн олговор	Нөлөөллийн бүсийн айлыг нүүлгэн шилжүүлэх боломжийг судлах	-
5	Түүх соёлын өвийг хамгаалах	Ажил төлөвлөөгүй	-
6	Осол эрсдэлийн менежмент	Уурхайд ажиллаж буй ажилчид бэртэж, гэмтэх, гал түймэрээс сэргийлэх арга хэмжээ авах	1500.0
7	Хог хаягдлын менежмент	Уурхайн хог цэгийг ариутгах, ангилан ялгалтыг сайжруулах	860.0
9	Орчны хяналт шинжилгээ	Усны хяналт шинжилгээ	500.0
		Хөрсний хяналт шинжилгээ	500.0
10	Удирдлага зохион байгуулалт		-
<b>НИЙТ ЗАРДАЛ</b>			<b>30060.0</b>

## 17 ДҮГНЭЛТ

Эвт чулуу ХХК нь Байгаль орчныг хамгаалах хууль тогтоомжийн дагуу Байгаль хамгааллын дүрэм журмыг чанд сахин, стандартуудыг мөрдлөг болгон ажиллаж байгаль орчинд учирч болох сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, хамгаалах, нөхөн сэргээх ажлыг тогтмол гүйцэтгэдэг билээ.

Цагаан даваа барилгын чулуу ордын 2025 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд сөрөг нөлөөллийг бууруулах, дүйцүүлэн хамгаалах, орчны хяналт шинжилгээ болон удирдлага зохион байгуулалтын зэрэг нийт 23 ажил хийгдэхээр тусгагдсанаас тайлант хугацааг хүртэл 22 ажлыг төлөвлөгөөний дагуу гүйцэтгэсэн, 95%-ийн биелэлттэй байна. Олон нийтэд тайлагнах үйл ажиллагааны хүрээнд хийгдэхээр тусгасан 3 ажлыг заасан хугацааны дагуу IV улиралд гүйцэтгэж, биелэлтийг тайлагнахаар байна.

2025 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд 20 938 000 төгрөг төлөвлөн тусгаж, тайлант оны X сарын байдлаар менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийг гаргахад 30 060 000 төгрөг зарцуулсан байна.